“Дуусаагүй амьдрал”

\Хөрөг найруулал\

Хэн бэ? хүн ирэв үү? Тийм ээ утсаар ярьсан охин байна. Тийм байх нь шинэ хүний дуу сонсогдлоо гэсээр нялх хүүхэд тэнтэр тунтар хөлд ордог шиг замд тааралдсан бүхнийг гараараа мэдэрсээр надруу дөхөв. Утас дуугарна 14:45 цаг. Дахин дуугарна 14:50. Хараагүй болохоор ингэж л амьдралдаа дасан зохицоно шүү дээ. Цаад өрөөнөөс гарч ирсэн эгч биеэ хөнгөрснийг гайхан дахин бариулах үгүйгээ асуун ах дасгал тогтмол хийхийг сануулан үдэн гаргалаа. Түшлэгтэй сандал байх ёстой үүн дээр суугаарай гэж бид хоёрын дуусашгүй яриа эхэллээ. Түүнийг Ж.Отгонбаяр гэдэг. Дорноговь аймгйн Хөвсгөл сумын уугуул Ц.Жанчивдоржийн арван хүүхдийн дундах хүү болон 1970 онд мэндэлжээ. 1978 онд тухайн үеийн хүн бүр хөдөлмөрлөх социалист нийгмийн нөлөөгөөр эцэг, эх нь арван хүүхдээ дагуулан төв газар бараадан Дорноговь аймгийн Сайншанд суманд аж төрөхөөр болжээ. 1983-1988 онд чөлөөт бөхөөр барилдан аймаг, бүсийн тэмцээнд оролцож спортын дэд мастер цол хүртэж, Дорноговь аймгийн чөлөөт бөхийн шигшээ багт барилдаж байснаа тод томруунаар санан дурсаж байгаа нь түүний амьдрал дахь хамгийн сайхан үе гэлтэй. Тэр үедээ л 52 килограммд барилддаг бөхчүүддээ унаж үзээгүйдээ гэж өөрийн дархан мэхээ үзүүлэх гэж хоёр гараа савчина. Сурсан зүйлийг сураар боож болдоггүй гэдэг шиг чөлөөт бөх түүний амьдралын нэгэн хэсэг байжээ.

Амьдралын нугачаа

Арван жилээ төгсөөд тухайн үед бүх юм ховордсон амьдралын эрээнтэй бараантай өдрүүдийн эрхээр чөлөөт бөхөө орхин, олдсон хар, бор ажлыг хийдэг байв. Цааш нь Их дээд сургууль гэж яваагүй тул яг тийм мэргэжилтэй хүн болно гэж бодоогүй ч боломж нь олдвол аавынхаа мэргэжлийг өвлөх санаатай байжээ. Аав Ц.Жанчивдорж нь Дорноговь аймгийн хүн. Тэтгэвэрт гартлаа тээвэрт жолооч хийсэн ба Ж.Отгонбаяр ах түүний мэргэжлийг өвлөөгүй ч гурван ах нь жолооч болжээ. 2003 оны хар дарсан өдрийг хэзээ ч мартдаггүй талаар халаглан ярьлаа. Яаж ч мартах билээ дээ туулах ёстой урт удаан гэгээлэг амьдралын замыг нь тасдан хаяж, бурханаас заясан хоёр нүдийг нь таглан хаяжээ. Амьдрал гэдэг хатуу хандахдаа үнэхээр л өршөөлгүй мэт. Анх уулзсан үеэс л Ж.Отгонбаяр ах утсаар залгасан хүн бүрт үгүй гэж хэлэхгүйгээр болгоно, чадна гэж хэлж байгаа дуулдана. 2003 оны намрын зөөлөн салхитай тэр орой гэр лүү гээ орох үеэр замд нь олон согтуу хүмүүс тааралдсан ба нэгийгээ нүүр нүдгүй балбаж байсан тул хаяж явж чадаагүй тэрээр муу зүйл болохоос сэргийлэн салгах гэж очжээ. Гэтэл улаан тоосго барьсан согтуу залуу нүүрэн дундуур нь дэлсээд авжээ. Нэг л мэдэхэд эмнэлэгийн орон дээр эмч, сувилагчдын хүрээлэл дунд сэржээ. “Отгонбаяраа тархиндаа хүнд гэмтэл авсан учир нэг нүд чинь хараагүй болсон, аажмаар зүүн нүдэнд чинь нөлөөлөн нөхөн сэргээгдэхгүйгээр бүрэн хараагаа алдана шүү” гэсэн эмчийн хэлсэн муу мэдээ түүнийг угтжээ. Сая л үүнийг сонсож баруун нүдээ харахгүй байгааг мэдэрсэн гэлтэй. Төрөлхөөсөө ийм байгаагүй тул өөрт ирсэн бодит зүйлтэй нүүр тулна, дасан зохицно гэдэг хэцүү. Архи уусан согтуугаас болж ийм болсон ч, архийг үзэн ядах аргагүй. Тэр л хань болж согтсондоо үүнийгээ мартан хэдэн цагаар ч болов унтана гэсээр 2009 онд бүрэн хараагаа алджээ. Хүнд гойд муу зүйл хийдэггүй ч хэзээ хийсэн үйлийн үрээр хувь тавилан ингэж хатуурхав гэж бодон үхэхийг хүссэн ч хүү охин хоёр нь балчир тул эхнэртээ өрх толгойлсон эмэгтэй гэх тэр их ачааг ганц биед үүрүүлэхийг хүссэнгүй. Хань гэдэг сайн ч муу ч хамт л байдаг хойно. Түүнийг гэмтээсэн хүн цагдаа хүн байжээ.

Архи гэдэг эзэмшсэн мэргэжил, ар гэрийн хүлээлт, бусдыг энэрэх сэтгэлийг нь уландаа гишгэн араатан болгож муу ёрын хорлол руу чирдэг нь юутай гаслантай. Шүүх хурал болсон ч хүний гэмшил нь хойноо байдгийн адил өвдөг сөгдөн уучлал эрэн долоон хүүхдээ өмнөө барин иржээ. Нэгэнт л түүний хараа ямар ч сайн эмнэлэг, алтан гарт эмчээр дамжин ахин сэргэхгүй учир тэрхүү долоон хүүхдийг өөрийн харанхуй амьдралын золиос болгохгүйн тулд элэг бүтэн өсөхийн ерөөлөөр тохиролцоонд хүрэн хохиролгүй байхаар шийджээ. Бусдын долоон хүүхдийн амьдралыг аврах байтугай 2011 онд мэндэлсэн өөрийн отгон хүүгийнхээ царайг хараагүй гэдэг. Хүү охин хоёрынх нь царай 2009 оныхоор л дүрслэгдэж, бага хүүгээ өөрийнхөө балчир байх үетэй адилхан хэмээн төсөөлнө. 2023 онд түүний анхны зээ охин мэндэлсэнд тэрээр мөн л ээжтэйгээ адилхан даа хэмээн баримжаа төдийхнөөр өөрийгөө аргадана. Хараагүй болсоноос хойш машинд дайруулах, даарсан ч гэртээ орж чадахгүй гадаа суух, уламжлалт бариагаа хүүхдийн биеийг 3000 төгрөгөөр барьдаг байсан ч гурван ширхэг 500 төгрөг атгуулан явах нэгнээс эхлүүлээд, бариулах нэрийдлээр ирэн өөрт байсан цаг, утас, хураасан хэдэн төгрөгөө алдах үе олонтоо таарсан. Гэвч энэ бүхнээс хамгийн хэцүү нь хайртай хүмүүсээ харахгүй байх, гарыг нь атгаж тусалсаныг харж чадахгүй байх л хамгийн хэцүү хэмээнэ.

Эхлэх цэг

Нэгэнт 2 нүд нь хараагүй болсоных бусдаас гуйн, өрөвдүүлэхийг хүсээгүй тэрээр насаараа туулах хүнд ачааныхаа боломжийг хайжээ. Харанхуй тал байсан ч нөгөө талд нь өчүүхэн гэрэл гэгээ байдгийн адил хараагаа алдсан тохиолдолд алдагдсан мэдрэхүй нь бусад мэдрэхүйдээ таран сонсгол нь сайжирч хүнийг дуу холойгоор нь ялгах, судасны цохилт болон хүний биеийн өвдөж буй эрхтнүүдийг илүү нарийвчлан мэдэрдэг болсон гэнэ. Үүнийг амьдралаа шинээр эхлүүлэх гараа гэж харан, анх 2013 онд Улаанбаатар хотод хараагүйчүүдийн холбоонд “Хараагүйчүүдийн нөхөн сэргээх” төвөөс явуулдаг япон бариа заслын зургаан сарын сургалтанд сурч, 2014-2015 онд Улаанбаатар хотод “Best massage” 14 газар ажиллан, 2016 онд Дорноговь аймгийн Айраг сумандаа ирж, өөрийн “Best massage” төвөө нээн одоог хүртэл тогтвортой үйл ажиллагаагаа явуулсаар иржээ. Энэ хугацаанд 3000-4000 хүнийг бариа заслаар эдгээж, үр тээж, жирэмсэн болж чадахгүй байгаа эмэгтэйчүүдийн савыг нь нээн 3-4 хүүхэд төрүүлэх, 2017 онд 12 настай тэргэнцэртэй ирсэн хүүг хөлд оруулан одоо сайхан залуу болсон гэж дурсан ярина. Холоос зорин ирэх үйлчлүүлэгч олонтой тэрээр Дорноговь аймгийн Мандах, Улаанбадрах, Сайхандулаан, Хэнтий аймгийн Бор-Өндөрөөс гээд Ж.Отгонбаяр ахын гараар эдгэж амьдралаа гэрэлтүүлдэг хүн цөөнгүй. Энэ бүх үйлчлүүлэгч, түмэн олны дэмжлэгээр амьдралаа залгуулж буй тэрээр том хүүгээ ДХИС-ын цагдаагийн анги, дунд охиноо ШУТИС-ын цахилгаан хангамжийн ангиар төгсгөж, сумандаа шинээр баригдсан байранд хоёр өрөө байр худалдан авч, саяхан үлдэгдэл төлбөрөө төлж барагдуулсан гэнэ. Ирэх онд Замын-үүд суманд “Best massage” төвөө нээх зорилготой байгаа ба хүн ам олонтой учир нарийн төлөвлөгөөтэй очиж байгаагаа хуваалцлаа. Өдөрт багаар бодоход 50000 төгрөгөөр дөрвөн хүн барихад 200 мянга, сард 6 сая, жилд 66 сая. 50 саяыг нь хуримтлалдаа хадгалан энэ эрчээрээ таван жил ажиллахад хотод маш сайхан гурван өрөө байртай болох зорилготой. Эцэст нь үр хүүхдүүддээ үлдээх өв хөрөнгө, хөгжлийн бэрхшээлтэй хүний хүүхэд гэж хэлүүлэхийг хүсэхгүй нүүр бардам хадамд гаргах хүсэл нь өнөөдрийн түүнийг бий болгоход хөшүүрэг болон иржээ.

Охин О.Ариунцэцэг: Амьдралд нэг хаалга хаагдахад нөгөө хаалга нээгддэг гэдэг. Аав минь тэр хоёр хаалганы дунд гацах биш нөгөө хаалгаа нээн алхам бүрээ төлөвлөсөөр энэ

хүртэл ирсэн. Аавын туулсан нугачаа бүрийн хажууд өөрт тохиолдсон хэцүүг харьцуулвал хаана нь ч хүрэхгүй тул аавын хажууд болон амьдралд хэцүү гэж хэлэхээс ичдэг.

Хараатай хүн, хараагүй хүн хоёрын дунд тэнгэр газар шиг асар их ялгаатай, олон зүйлийг туулдаг ч тэр бүхэнд бөхийн унахгүй сэтгэлийн их хат, айл гэрийн ноён гэх нэр төрдөө эзэн байсаар ирсэн Ж.Отгонбаяр ахын амьдралын туулсан бүхний нэг хуудсыг та бүхэнд хүргэхийг зорилоо.

МУИС-Сэтгүүл зүй олон нийтийн харилцаа

тэнхимийн 4-р түвшний оюутан У.Мөнхнаран

Холбогдох утас:95185840